



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



**Зүүнхангай сумын төсвийн байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, Бараа материал болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналт сул байна**

**Зүүнхангай сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн**

УВС-2017/07-НА

2017 оны 10 дугаар сар

УВС-2017/07-НА

|                                                                                                                                                                 |                                                                                                                           |           |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>Тайлан бэлтгэсэн:</b>                                                                                                                                        | <b>Агуулга</b>                                                                                                            | <b>3</b>  |
| <b>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор</b><br>М.Батсуурь                                                                                                             | <b>Товчилсон үг</b>                                                                                                       | <b>4</b>  |
| <b>Аудитын менежер</b><br>М.Бат-Амгалан                                                                                                                         | <b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b>                                                                           | <b>5</b>  |
| <b>Ахлах аудитор</b><br>Б.Авирмэд                                                                                                                               | <b>Ерөнхий мэдээлэл</b>                                                                                                   | <b>6</b>  |
| <b>Аудитор</b><br>Т.Намжил                                                                                                                                      | <b>Бүлэг 1. Батлагдсан төсвийн зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.</b>                                       | <b>7</b>  |
| 2017 оны 10 дугаар сар                                                                                                                                          | 1.1. Батлагдсан төсвийн зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.                                                  | 7         |
|                                                                                                                                                                 | 1.2. Цалин хөлс, нэмэгдлийг олгохдоо зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байна.                                        | 10        |
|                                                                                                                                                                 | 1.3. Авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнасан байна                                                                      | 11        |
|                                                                                                                                                                 | 1.4. Төсөвт байгууллагуудын бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна. | 12        |
|                                                                                                                                                                 | <b>Бүлэг 2. Бараа материал болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналт сул байна</b> | <b>13</b> |
|                                                                                                                                                                 | 2.1. Бараа материалын зарцуулалтанд тавих хяналт сул байна.                                                               | 13        |
|                                                                                                                                                                 | 2.2. Үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналт сул байна.                                | 14        |
| Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317, 7045-3721, 70453799, 7045-4721 дугаарын утсаар харилцана уу. | <b>Бүлэг 3. Эмийн эргэлтийн сангийн зарцуулалтын талаар</b>                                                               | <b>17</b> |
|                                                                                                                                                                 | 3.1. Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна.                                | 17        |
|                                                                                                                                                                 | 3.2. Эмийн эргэлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хэвийн, зарцуулалтанд тавих хяналт байна.                                | 17        |
|                                                                                                                                                                 | 3.3. Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт хэвийн байна.                                                 | 18        |
|                                                                                                                                                                 | 3.4. Эмийн эргэлтийн сангийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна.                                                       | 19        |
|                                                                                                                                                                 | <b>Бүлэг 4. Шилэн дансы тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна.</b>                                                         | <b>19</b> |
|                                                                                                                                                                 | 4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна.                                                                   | 19        |
|                                                                                                                                                                 | 4.2. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.                                  | 20        |
| <b>Хаяг:</b><br>Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Улаангом сум, 3 дугаар баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр                                      | <b>Дүгнэлт</b>                                                                                                            | <b>21</b> |
|                                                                                                                                                                 | <b>Зөвлөмж</b>                                                                                                            | <b>22</b> |
|                                                                                                                                                                 | <b>Холбогдох байгууллагын санал</b>                                                                                       | <b>23</b> |
|                                                                                                                                                                 | <b>Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар</b>                                                                | <b>24</b> |

**Товчилсон үгийн тайлал:**

|    |               |                                                                                           |
|----|---------------|-------------------------------------------------------------------------------------------|
| 1  | УИХ           | Улсын Их Хурал                                                                            |
| 2  | ҮАГ           | Үндэсний аудитын газар                                                                    |
| 3  | АДБОУС        | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт                                             |
| 4  | НА            | Нийцлийн аудит                                                                            |
| 5  | ИТХ           | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                                                              |
| 6  | ЗДТГ          | Засаг даргын тамгын газар                                                                 |
| 7  | ЭМТ           | Эрүүл мэндийн төв                                                                         |
| 8  | ЭЭС           | Эмийн эргэлтийн сан                                                                       |
| 9  | НББ           | Нягтлан бодох бүртгэл                                                                     |
| 10 | ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| 11 | ШТС           | Шатахуун түгээх станц                                                                     |
| 12 | ОНХС          | Орон нутгийн хөгжлийн сан                                                                 |
| 13 | ГХУСЗ         | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал                                                   |
| 14 | ХХК           | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                                      |

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

### **Аудитын нэр**

Увс аймгийн Зүүнхангай сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн.

### **Аудитын код**

УВС-2017/07-НА

### **Аудитын зорилт**

Зүүнхангай сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсөв, хөрөнгө нөөцөө хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт гарган, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;
- Үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавигдах хяналт байгаа эсэх;
- Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;
- Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт;

### **Аудитын хамрах хүрээ**

Зүүнхангай сумын төсөвт байгууллагууд, эмийн эргэлтийн сан болон холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

### **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тайлбар авах, мэдээ гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл, анхан шатны баримтыг тулган баталгаажуулах, бараа материал, үндсэн хөрөнгөд биет тооллого хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горимын дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Нийцлийн аудитыг ахлах аудитор Б.Авирмэд ахалж, аудитор Т.Намжил нар 2017 оны 09 дүгээр сарын 18-наас 10 дугаар сарын 09-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

## СУМЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Увс аймгийн Зүүнхангай сум нь 1924 онд “Бадрах” нэртэй байгуулагдаж, 1932 онд Зүүнхангай сум болон нэрээ өөрчилж 10 баг, 755 өрх, 2949 хүн амтай байгуулагдаж байсан. 2016 оны жилийн эцсийн байдлаар тус сум нь Даланбулаг, Баянгол, Жаргалант, Хайрхан гэсэн 4 багийн нийт 622 өрхийн 2261 хүн ам, 215.4 мянган толгой малтай байна.

### **Эдийн засгийн бүтэц**

Сумын хэмжээнд нийт 30 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 170,1 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлж улсад 1,6 сая, аймагт 3,3 сая, орон нутагт 26,7 сая нийт 31,6 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

Сумын хэмжээнд ИТХ, ЗДТГ, Ахлах сургууль, ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв гэсэн төрийн байгууллага болон арилжааны ХААН банк, Төрийн банк, ШТС, холбооны салбар, худалдаа, үйлчилгээний чиглэлийн хувийн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

Нийцлийн аудитын хамрах хүрээнд ИТХ-ын даргаар Ч.Батхишиг, Д.Батболд, Засаг даргаар Б.Зулбаяр, Ж.Батбаяр, ЗДТГ-ын даргаар Х.Өсөхбаяр, О.Цэрэндорж, Ахлах сургуулийн захирлаар С.Батчулуун, Эрүүл мэндийн төвийн эрхлэгчээр Э.Эрдэнэцэцэг, Ц.Эрдэнэчимэг, Ж.Мөнх-Од, Ц.Ганбаатар, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчээр М.Сарантуяа, Соёлын төвийн эрхлэгчээр Д.Төгсхаан, Б.Баяраа, С.Түмэндэлгэр, ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргаар Б.Баяртайханцэцэг, М.Бямбадорж, төсөв, төрийн сангийн мэргэжилтнээр М.Бямбадорж, О.Энхбаяр, ИТХ, ЗДТГ, Ахлах сургуулийн нягтлан бодогчоор Б.Бадамханд, Л.Анхбаяр, Эрүүл мэндийн төв, Эмийн эргэлтийн сан, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн нягтлан бодогчоор К.Бибиш нар ажиллаж 1, 2 –р гарын үсэг зурж төсөв хөрөнгийг захиран зарцуулсан байна.

Эмийн эргэлтийн сангийн 1-р гарын үсгийг сумын Засаг дарга, 2-р гарын үсгийг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч зурж захиран зарцуулсан байна. Эмийн эргэлтийн сангийн эрхлэгчээр М.Мөнхбаяр ажиллаж байна.

Зүүнхангай суманд нийцлийн аудит хийх явцад төсвийн байгууллагууд болон Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал хүсэлтийг хүлээн авахаар зарлал байрлуулж ажиллаа.

**Бүлэг: 1 Батлагдсан төсвийн зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.**

**1.1 Батлагдсан төсвийн зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.**

Зүүнхангай сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

| Д/Д | Байгууллагын нэр | 2015 он        |                |                  | 2016 он        |                |                  |
|-----|------------------|----------------|----------------|------------------|----------------|----------------|------------------|
|     |                  | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | хэтрэлт, хэмнэлт | төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | хэтрэлт, хэмнэлт |
| 1   | ЗДТГ             | 310.07         | 309.73         | 0.34             | 278.78         | 277.05         | 1.73             |
| 2   | ИТХ              | 62.11          | 59.8           | 2.31             | 41.05          | 37.18          | 3.87             |
| 3   | Сургууль         | 596.67         | 588.43         | 8.24             | 698.37         | 698.06         | 0.31             |
| 4   | Цэцэрлэг         | 169.58         | 168.99         | 0.57             | 211.69         | 210.93         | 0.76             |
| 5   | Соёл             | 45.89          | 43.16          | 2.73             | 50.22          | 49.54          | 0.68             |
| 6   | ЭМТөв            | 294.72         | 292.78         | 1.94             | 288.62         | 281.6          | 7.02             |
|     | <b>Дүн</b>       | <b>1479.04</b> | <b>1462.89</b> | <b>16.13</b>     | <b>1568.73</b> | <b>1554.36</b> | <b>14.37</b>     |

/сая. төг/

**Эх сурвалж: Сумын ЗДТГ-ын Санхүүгийн алба**

Сумын төсөвт байгууллагууд 2015 онд 16,1 сая, 2016 онд 14,4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38-д “Төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ”, Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал төсөвтэй байх бөгөөд түүнийг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна” гэж заасан байхад 2016 оны 9 дүгээр сар хүртэл сумын ИТХ-ын төсвийн 1 дүгээр гарын үсгийг төсвийн төвлөрүүлэн захирагч болох ИТХ-ын дарга зурж төсөв хөрөнгийг захиран зарцуулж байсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан байхад ИТХ, ЗДТГ, Ахлах сургууль анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар төлбөр тооцоог гүйцэтгэсэн зөрчил илэрлээ. Тухайлбал:

- ИТХ-ын ГХУСЗ-ын зарцуулалтын баримтын бүрдэл дутуу,
- ЗДТГ-ын Засаг даргын нөөцөөс захирамжаар гарсан зардлын зарцуулалтын баримтын бүрдэл дутуу,
- ЗДТГ, Ахлах сургуулийн гүйлгээнд зарим харилцагч байгууллагын нэхэмжлэх, орлогын баримтанд гарын үсэг, тамга тэмдэг байхгүй тоо хэмжээ, нэгж үнийг тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчиж Эрүүл мэндийн төв төсөл хөтөлбөрийн зардлын 9025.2 мянган төгрөгийг 31 арга хэмжээнд зарцуулснаас 7967.3 мянган төгрөгийг 26 арга хэмжээнд хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зориулалт бусаар зарцуулсан, зарцуулалтын тайлан байхгүй байсанд зөрчил арилгуулахаар албан шаардлага өглөө.

Ахлах сургууль 2016 оны 4 дүгээр сард “Ганболор тулга” ХХК-д үдийн цай хөтөлбөрийн материалын үнэ шилжүүлэхдээ 1382.5 мянган төгрөгийн нэхэмжлэлийн хөлийн дүнг хөндий өсгөн 1823.5 мянган төгрөг шилжүүлэн зөрүү 441.0 мянган төгрөгийг үндэслэх баримтгүйгээр илүү олгосоныг Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1.3-д “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосонд төлбөрийн акт тогтооно” гэж заасны дагуу төлүүлэхээр акт тогтоолоо.

Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 9-д “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарын бүх хоногоор тооцож гаргана. Тэгэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно”, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар албан томилолтын зардлын дээд хэмжээг тогтоох тушаалын 1-д “... Улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам, хоног байрны зардлын хэмжээг суманд 18000 төгрөг, аймгийн төвд 29000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 35500 төгрөгөөр, төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг суманд 12000 төгрөг, аймгийн төвд 14000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 16000 төгрөгөөр тус тус тогтоосон...”-ыг зөрчин сумын ИТХ, ЗДТГ, Ахлах сургуулийн зарим ажилтны албан томилолтоор ажилласан зам хоногийг илүү, дутуу тооцсон, албан томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас хөтлөөгүй зөрчил илэрснийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг зөвлөв.

Цэцэрлэгийн хүүхдийн ирцийг шалгалтанд хамрагдсан онуудад тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Зүүнхангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн ирц 2015, 2016 он

| Он   | Сар | Бүлгүүд |       |      |      | журнал | Өдөр бүрийн зарлага | зөрүү |
|------|-----|---------|-------|------|------|--------|---------------------|-------|
|      |     | бэлтгэл | ахлах | дунд | бага |        |                     |       |
| 2015 | 1   | 556     | 421   | 406  | 421  | 1804   | 1815                | 11    |
|      | 2   | 430     | 299   | 331  | 413  | 1473   | 1472                | -1    |
|      | 3   | 737     | 378   | 462  | 531  | 2108   | 2019                | 11    |
|      | 4   | 718     | 446   | 439  | 622  | 2225   | 2263                | 38    |
|      | 5   | 735     | 334   | 376  | 575  | 2020   | 1899                | -121  |
|      | 9   | 419     | 528   | 533  | 504  | 1984   | 1983                | -1    |
|      | 10  | 565     | 564   | 472  | 452  | 2053   | 2054                | 1     |
|      | 11  | 536     | 543   | 425  | 461  | 1965   | 1896                | -69   |
|      | 12  | 416     | 610   | 449  | 591  | 2066   | 1986                | -80   |
| 2016 | 1   | 330     | 477   | 295  | 531  | 1633   | 1633                | 0     |
|      | 2   | 260     | 297   | 217  | 369  | 1143   | 1165                | 22    |
|      | 3   | 391     | 466   | 423  | 610  | 1890   | 1898                | 8     |
|      | 4   | 395     | 465   | 397  | 535  | 1792   | 1824                | 32    |
|      | 5   | 359     | 389   | 339  | 414  | 1501   | 1561                | 60    |
|      | 9   | 542     | 496   | 551  | 483  | 2072   | 2047                | -25   |
|      | 10  | 496     | 445   | 531  | 454  | 1926   | 1922                | -4    |
|      | 11  | 516     | 504   | 496  | 505  | 2021   | 1973                | -48   |
|      | 12  | 547     | 487   | 402  | 517  | 1953   | 1972                | 19    |
|      | дүн | 8948    | 8149  | 7544 | 8988 | 33629  | 33382               | -147  |

Эх сурвалж: Ангийн багшийн журнал, өдөр тутмын хоолны почёнк

Дээрх судалгаанаас харахад багшийн журналын бүртгэл хоолны почёнк дээрх хүүхдийн ирцийн бүртгэл сар бүр зөрүүтэй байгаа нь хүнсний материал илүү, дутуу олгогдох эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцана” гэж заасныг зөрчиж байна.

Цаашид хүүхдийн ирцийн бүртгэлийг бүртгэлийг үнэн зөв хөтөлж байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

2015 онд “Цавдан” гэр цэцэрлэгийн багшийг томилсон тушаал он сар, дугааргүй, хэдэн сарын хэдний өдрөөс ажиллаж эхэлсэн нь тодорхойгүйгээс хэдэн өдөр ажилласныг тогтоох боломжгүй байна. Цаашид архив албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлага хангасан тушаал шийдвэр гаргаж байхыг холбогдох албан тушаалтанд зөвлөлөө.

Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, засвартай, цагийн бүртгэлийг хянаж баталгаажуулаагүй, цалингийн цэсэнд гарын үсэг зуруулаагүй зөрчил байгааг анхаарч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөв.

## 1.2 Цалин хөлс, нэмэгдлийг олгохдоо зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагууд батлагдсан орон тоонд багтаан ажиллажээ. Төсөвт байгууллагууд оны эхэнд албан тушаал, ажилтнуудын ажилласан жил, цалингийн сүлжээ, шатлал, үндсэн цалин, нэмэгдлийн хувь хэмжээг тогтоож баталсан тушаал шийдвэр гаргасан байна.

Төсөвт байгууллагуудын бүтэц, орон тоо

| Байгууллагын нэр  | 2015 он    |            |                  | 2016 он    |            |                  |
|-------------------|------------|------------|------------------|------------|------------|------------------|
|                   | Батлагдсан | Гүйцэтгэл  | хэтрэлт, хэмнэлт | Батлагдсан | Гүйцэтгэл  | хэтрэлт, хэмнэлт |
| ИТХурал           | 2          | 2          | -                | 2          | 2          | -                |
| ЗДТГазар          | 20         | 22         | 2                | 20         | 22         | 2                |
| ЭМТөв             | 21         | 21         | -                | 21         | 21         | -                |
| Ахлах сургууль    | 61         | 61         | -                | 52         | 51         | (1)              |
| Хүүхдийн Цэцэрлэг | 15         | 15         | -                | 15         | 15         | -                |
| Соёлын төв        | 5          | 5          | -                | 5          | 5          | -                |
| <b>Бүгд дүн</b>   | <b>124</b> | <b>126</b> | <b>2</b>         | <b>115</b> | <b>116</b> | <b>1</b>         |

Эх сурвалж: Сумын ЗДТГ-ын Санхүүгийн алба

ЗДТГ-ын батлагдсан бүтэц орон тоонд байхгүй үйлчлэгч, сантехникч ажиллуулж байгаагаас шалтгаалан 2 орон тоогоор хэтэрсэн байна. Ахлах сургууль биеийн тамирын арга зүйчийн орон тоог хассанаас шалтгаалан 1 орон тоо хэмнэгдсэн байна.

ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 52 тоот тогтоолоор нарийн бичгийн дарга асан Ш.Арьхад салбарын тэргүүний ажилтан болсон тул дагалдах мөнгөн шагналд 100.0 мянган төгрөг олгохоор шийдвэр гарсан байхад 22.0 мянган төгрөг дутуу олгосон байна. Цаашид тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлөө.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 393 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам”-ын 2.5-д “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд үр дүнгийн урамшил олгох эсэх асуудлыг тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан холбогдох үнэлгээг харгалзан шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчин төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсанд 1457.7 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

- Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч М.Сарантуяад 2016 оны 12 сард 45 хувиар тооцож урамшил олгохоор цохолт хийсэн байхад 90 хувиар тооцож 320.1 мянган төгрөг
- Соёлын төвийн 2016 оны батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй Орон нутаг судлах музейн ажлыг номын санч С.Энхжаргалд хавсран ажиллуулах тушаал гарган 1137.6 мянган төгрөг олгосон

“Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам”-ын 1.2-д “Үр дүнгийн урамшлыг төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын (цаашид “сургалтын байгууллага” гэх) багш, бусад албан хаагчид ажлын үр дүнг нь харгалзан олгоно”, 2.2-д “Үр дүнгийн урамшлыг энэхүү журмын 2.4, 2.5-д заасан шийдвэрийг үндэслэн сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчийн үндсэн цалингаас 70-80 оноо авсан бол-10 хувь, 81-90 оноо авсан бол-13 хувь, 91-100 оноо авсан бол-15 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно”, 2.3-д “Төрийн өмчийн сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчийн ажлыг үнэлж, дүгнэх журамд заасан шалгуурын биелэлт 70-аас доош хувьтай үнэлэгдсэн тохиолдолд тухайн албан хаагчид үр дүнгийн урамшил олгохгүй” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг ажилтны ээлжийн амралттай байх хугацааг оруулан тооцож улирлын урамшилыг илүү олгосон, Ахлах сургууль улирлын ажлын үр дүнгийн үнэлгээгээр 70-аас доош үнэлгээ авсан ажилтанд урамшил олгосон.
- Ахлах сургуулийн захирал, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга нар улирлын урамшил авахдаа ажлаа дүгнүүлээгүй, Засаг даргын захирамжгүй өөртөө тушаал гаргаж, сумын Засаг даргаар цохолт хийлгэсэн байна.

Цаашид улирлын урамшил олгохдоо Засгийн газрын 393 дугаар тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

### 1.3 Авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнасан байна.

Сумын төсөвт байгууллагуудын авлага, өр төлбөр дараах байдалтай байна.

| Д/д | Байгууллагын нэр  | Авлага        |          | Өр, төлбөр      |                |
|-----|-------------------|---------------|----------|-----------------|----------------|
|     |                   | 2015          | 2016     | 2015            | 2016           |
| 1   | ИТХ               | 53232         | 0        | 143232          | 0              |
| 2   | ЗДТГ              | 526470        | 0        | 7144480         | 0              |
| 3   | Ахлах сургууль    | 0             | 0        | 17514773        | 1321250        |
| 4   | Хүүхдийн цэцэрлэг | 0             | 0        | 22100           | 22100          |
| 5   | ЭМТ               | 0             | 0        | 0               | 590000         |
| 6   | Соёлын төв        | 90275         | 0        | 90275           | 0              |
|     | <b>Нийт дүн</b>   | <b>669977</b> | <b>0</b> | <b>24914860</b> | <b>1943350</b> |

/ мян.төг /

Эх сурвалж: Сумын ЗДТГ-ын Санхүүгийн алба

2015 онд ЗДТГазар 526.5 мянга, ИТХурал 53.2 мянга, Соёлын төвийн 90.3 мянга, нийт 670.0 мянган төгрөгийн авлага нь оны эцэст шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн гүйлгээ буцаж орж ирснийг орон нутгийн орлого болон улсын төсөвт төвлөрүүлснээс үүссэн байна.

2015 оны өглөг нь жил эцсийн мал тооллогын зардал, шатахууны үнийн өсөлт, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой үүсчээ. 2016 онд өглөг буурсан байна.

#### 1.4 Төсөвт байгууллагуудын бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу 2015, 2016 онд Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХСангийн зарцуулалтад гүйцэтгэл, нийцлийн аудит хийсэн тул тендер худалдан авалтын холбогдох баримтыг дахин шалгах шаардлагагүй гэж үзсэн.

Аудитын явцад сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны шатах тослох материалын баримт болон Ахлах сургуулийн үдийн цай хөтөлбөрийн баримт, Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн хүнсний материалын 2015 оны тендер сонгон шалгаруулалтын баримт материалыг ирүүлээгүй бөгөөд тендер зарласан эсэх нь тодорхойгүй байна.

Харин төсөвт байгууллагуудын 2016 оны хүнсний материал болон үдийн цай хөтөлбөрийн тендер худалдан авалттай холбоотой баримтыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Харьцуулалтын аргыг яаж хэрэглэсэн нь тодорхойгүй,
- Үнийн саналаар хэрхэн жагсааж эрэмбэлснийг холбогдох баримтаас харах боломжгүй,
- Үнэлгээний хорооны гишүүн бүр үнэлгээний хуудас хөтөлж нэгтгээгүй,
- Үнэлгээний хорооноос гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээгүй.

Ахлах сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэгийн хүнсний материал, Ахлах сургуулийн үдийн цай хөтөлбөрт материал нийлүүлэх гэрээний үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

/2016 он/

| № | Байгууллагын нэр  | Бэлтгэн нийлүүлэгч   | Нийлүүлэх бүтээгдхүүн ий нэр | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Гарын үсэг тамга        |
|---|-------------------|----------------------|------------------------------|------------|-------------|----------|-------------------------|
| 1 | Ахлах сургууль    | Тэгш буянт булаг     | Тийм                         | Үгүй       | үгүй        | үгүй     | Тийм                    |
| 2 | Ахлах сургууль    | Дулаан аз            | Тийм                         | Тийм       | үгүй        | үгүй     | Тийм                    |
| 3 | Ахлах сургууль    | Бууч үржих           | Тийм                         | Үгүй       | үгүй        | үгүй     | Тамгагүй                |
| 4 | Ахлах сургууль    | Сүлд өгөөж           | Тийм                         | Үгүй       | үгүй        | үгүй     | Тийм                    |
| 5 | Ахлах сургууль    | Ганболор тулга       | Тийм                         | Үгүй       | үгүй        | үгүй     | Тийм                    |
| 6 | Ахлах сургууль    | Дулаан Аз            | Тийм                         | Тийм       | тийм        | үгүй     | Тийм                    |
| 7 | Хүүхдийн цэцэрлэг | Дулаан Аз            | Тийм                         | Үгүй       | үгүй        | тийм     | Тийм                    |
| 8 | Хүүхдийн цэцэрлэг | Зүүн ханхөхийн уянга | Үгүй                         | Үгүй       | үгүй        | үгүй     | нийлүүлэгчийн х байхгүй |
| 9 | Хүн эмнэлэг       | Дулаан Аз            | Тийм                         | Тийм       | үгүй        | тийм     | Үгүй                    |

Эх сурвалж: Сумын тендер худалдан авах ажиллагааны баримт

[illegible]

Дээрх хүснэгтээс харахад бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ нь шаардлага хангахгүй байна. Зарим гэрээнд ямар бүтээгдэхүүнийг хэдэн төгрөгөөр нийлүүлэх нь тодорхой бус, зөвхөн нийт үнийн дүн тавьсан, гарын үсэг, тамга тэмдэг дутуу зэрэг зөрчилтэй байна. Энэ нь бүтээгдэхүүний тоо, чанарт тавих хяналт алдагдах, үнийн зөрүү үүсэх, төсвийн хөрөнгө хяналтгүй, зориулалт бусаар зарцуулагдах эрсдэл үүсгэж байна.

Цаашид ТБОНӨХБАҮХАТухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

**Бүлэг: 2      Бараа материал болон үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.**

## 2.1 Бараа материалын зарцуулалтад тавих хяналт сул байна.

Аудитын явцад Ахлах сургуулийн байрны багшийн ирцийн бүртгэл өдөр тутмын хоолны почёнк, нярвын тайлан, материалын үлдэгдлийг тулган шалгахад зарцуулалтын хувьд таарсан хэдий ч дараах зөрчил байна. Тухайлбал:

- 2015 оны зарим сарын дотуур байрны хүүхдийн ирцийн бүртгэл байхгүй,
- Нярав хүнсний материалын сар бүрийн зарлагын тайлан гаргахдаа олон төрлийн үнэтэй өөр өөр малын махыг нийтэд нь нэг үнээр зарлагаддаг,
- Хоолны почёнк засвартай,
- зарим өдрийн хоолны почёнк байхгүй,
- зарим өдрийн хоолны почёнк зарлагын тайлан хоорондоо зөрүүтэй,
- Зарлагын тайлангийн хөлийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь гүйцэтгэгч ажилтан болон шат шатны хяналт тавих эрх, үүрэг бүхий албан тушаалтнуудын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна. Цаашид анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдлыг ханган, өдөр тутамд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг зөвлөв.

Сумын төсөвт байгууллагуудын замын хуудсанд тухайн ажлаар явсан албан тушаалтны болон жолоочийн гарын үсэггүй, нягтлан бодогч шатах тослох материалын тооцоо бодоогүй, шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, гадны машинаар явсан үедээ замын хуудас хөтөлдөггүй, бензиний мөнгө бэлнээр гарган зарцуулсан зэрэг нийтлэг зөрчил байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 7 дугаар хавсралтад заасан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримталж тооцоо хийх аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал:

- 2015, 2016 онд ИТХ 1124.9 мянга, ЗДТГ 12845.5 мянга, Эрүүл мэндийн төв 7739.4 мянга, Ахлах сургууль 4790.7 мянга, Хүүхдийн цэцэрлэг 2199.9 мянга, Соёлын төв 309.3 мянган төгрөгийн шатах тослох материалыг замын хуудасгүй зарцуулсан.
- Сумын бүх төсөвт байгууллагуудын нягтлан бодогчид шатах тослох материалын тооцоо бодоогүй.
- ИТХ, ЗДТГ, Ахлах сургууль шатахууны зарим нэхэмжлэлд бэлэн мөнгө гэж бичсэн нь шатахуун авсан эсэх нь тодорхойгүй.
- ЗДТГ, Ахлах сургууль, ЭМТ байгууллагынхаа машинд хөтөлсөн замын хуудас нь хэрэглэгч, жолоочийн гарын үсэггүй, эрх бүхий албан тушаалтан баталгаажуулаагүй.
- ЭМТ-ийн автомашины спидометрийн заалтаар 2016 оны 3,4 дүгээр сард 130-140 мянган км явсан байхад замын хуудсанд спидометрийн заалтыг 70-80 мянган км явснаар хөтөлж 440 л шатахуун зарцуулсан.

Дээрх зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болгов.

Аудитын явцад төсөвт байгууллагуудын хөрөнгө, материалын үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийж, бараа материалын тайлангийн үлдэгдлийг тооллогын үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад Хүүхдийн цэцэрлэг 4801.1 мянган төгрөгийн 1410.2 кг мах дутагдлаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэж заасныг зөрчиж байгаа тул холбогдох хүмүүсээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Түүнчлэн холбогдох албан тушаалтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн 28.1-д “.....гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

## **2.2 Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-д “Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна” гэж заасан байна.

Сумын төсөвт байгууллагуудын төсвийн менежерийн тушаалаар өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилон ажиллуулж байна.

Аудитын явцад төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөд хэсэгчилсэн тооллого хийхэд ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Ахлах сургуулийн зарим үндсэн хөрөнгө биетээр байхгүй байлаа. Тухайлбал;

- Ахлах сургууль 2013 онд 3 ш бөмбөр худалдан авахаар 165.0 мянган төгрөгийг “Оргилжейд” ХХК-д, 1 ш гитар худалдан авахаар 160.0 мянган төгрөгийг “Эгшиглэн магнай” ХХК-д тус тус шилжүүлсэн ч уг хөрөнгүүд биетээр ирээгүй,
- Засаг дарга асан Б.Зулбаяр ажлаас гарахдаа ЗДТГ-ын 1249.9 мянган төгрөгийн үнэ бүхий Ienovo-360 маркийн суурин компьютер, сумын Засаг даргын орлогч асан М.Сэргэлэнбат 296.5 мянган төгрөгийн үнэ бүхий laserjet 3 үйлдэлт принтерийг өгөөгүй дутагдуулсан,
- ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Одгэрэл ажлаас гарахдаа 1153.9 мянган төгрөгийн үнэ бүхий и-3421 маркийн зөөврийн компьютер, 494.9 мянган төгрөгийн үнэ бүхий Nikon I-310 маркийн зургийн аппарат, 90.0 мянган төгрөгийн үнэ бүхий Жи-мобайлын суурин утас, нийт 1738.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээлгэн өгөөгүй дутагдуулсан,
- Эрүүл мэндийн төвийн 2008 онд ашиглалтанд орсон 1500.0 мянган төгрөгийн өртөгтэй зүрхний бичлэгийн аппарат байхгүй байлаа.

Дээрх зөрчилд НББ-ийн тухай хуулийн 12.4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.1.4-д “Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ” гэж заасны дагуу буруутай хүмүүсээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Соёлын төвд хөрөнгө оруулалтаар 2014 онд ирсэн 18.0 сая төгрөгийн үнэ бүхий кино театрын иж бүрдлийг данс бүртгэлд тусгаж орлогод аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана”, Сангийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 5.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр нь тухайн төсөвт байгууллагын тайлан балансад бүртгэнэ” гэж заасныг зөрчиж байгаа тул хөрөнгийг байгууллагын данс бүртгэлд тусгахыг албан шаардлага болголоо.

Сумын ЗДТГ, Ахлах сургууль, Эрүүл мэндийн төв Монгол улсын дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 9 дүгээр хавсралтанд заасан “Резинэн дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг баримтлаагүй, автомашинд сэлбэг тавихдаа өмч хамгаалах зөвлөлийн акт үйлдээгүй байна. Тухайлбал;

- Эрүүл мэндийн төв 720.0 мянган төгрөгийн дугуй, 180.0 мянган төгрөгийн зай хураагуур,
- ЗДТГ 150.0 мянган төгрөгийн дугуй,
- Ахлах сургууль 155.0 мянган төгрөгийн зай хураагуур худалдан авахдаа нормыг тогтоож, өмч хамгаалах зөвлөлийн акт үйлдээгүй байна.

Цаашид уг тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөв.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчин 2017 оны 7 сард байгууллагуудын ойн арга хэмжээний үеэр хандиваар ирсэн дараах хөрөнгүүдийг орлогод аваагүй, байгууллагын данс бүртгэлд бүртгээгүй байна. Тухайлбал;

- Эрүүл мэндийн төв 23 нэр төрлийн 44522.1 мянга,
- Хүүхдийн цэцэрлэг 13 нэр төрлийн 9200.0 мянга,
- Соёлын төв тайзны хөшиг 1181.0 мянга,
- Ахлах сургууль 52 нэр төрлийн 19322.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.

Дээрх хандиваар ирсэн 74225.7 мянган төгрөгийн 89 нэр төрлийн хөрөнгийг орлогод авч данс бүртгэлд тусгахыг зөвлөмж болгов.



Орон нутаг судлах кабинетийн 106 нэр төрлийн 21.5 сая төгрөгийн 241 ширхэг үзмэр зориулалтын бус байранд эмх цэгцгүй хадгалагдаж байгаа нь соёлын биет өвүүд эвдэрч гэмтэх улмаар устаж алга болох эрсдэлтэй байгаад анхаарал хандуулж ажиллахыг сумын удирдлагууд, холбогдох албан тушаалтанд зөвлөв.

Сумын төсөвт байгууллагууд ашиглалтын хугацаа дуусч цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгөө сүүлийн 3 жил акталж устгаагүй байна. Үүнд:

- ИТХ 11 нэр төрлийн 2605.5 мянга,
- ЗДТГ 24 нэр төрлийн 3482.9 мянга,
- Ахлах сургууль 38 нэр төрлийн 9438.8 мянга,
- Эрүүл мэндийн төв 15 нэр төрлийн 5877.1 мянга,
- Соёлын төв 22 нэр төрлийн 3333.8 мянга,
- Хүүхдийн цэцэрлэг 9 нэр төрлийн 3128.5 мянган төгрөгийн хөрөнгийг устгаагүй байна.

Төсөвт байгууллагууд ашиглалтын хугацаа дууссан дээрх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн сумын ИТХ-д шаардлагатай баримт материалыг бүрдүүлэн хүргүүлж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг зөвлөмж болголоо.

Эрүүл мэндийн төвийн хөрөнгөнд тооллого хийхэд 2006 онд бэлтгэсэн 429.4 мянган төгрөгийн үнэ бүхий сэнстэй матрас байхгүй байсныг эд хариуцагчаас тодруулахад өмнө нь ажиллаж байсан нярваас хүлээж аваагүй гэсэн тайлбар өгөв. Харин аудитын явцад тухайн хөрөнгө байгууллагын складад баглаа боодолтой шинээрээ хадгалагдаж байсан нь тогтоогдсон. Энэ нь нэг талаас хэрэгцээгүй хөрөнгө бэлтгэж 11 жил шинээр нь хадгалсан, нөгөөтэйгүүр байгууллагын хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт сул байгааг харуулж байна.

Мөн Эрүүл мэндийн төвийн цахилгаан мотор, Соёлын төвийн сунадаг шат хувь иргэнд ашиглагдаж байсан нь хөрөнгө эвдэрч гэмтэх, устаж алга болох эрсдэлтэй байна.

Иймд хөрөнгийн хадгалалт хамгаалтад тавих хяналтыг сайжруулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болгов.

### **Бүлэг: 3      Эмийн эргэлтийн сангийн зарцуулалтын талаар**

#### **3.1      Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна.**

Аймгийн Засаг даргын 2013 оны А/674 дугаар захирамжаар баталсан “Сумын Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ын 2.1-д аймагт эмийн эргэлтийн сан мэргэжлийн болон санхүүгийн удирдлагаар хангах удирдах зөвлөл, суманд эмийн эргэлтийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах сумын удирдах зөвлөл, хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл тус бүр ажиллана”, 2.2-д “Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд аймгийн удирдах зөвлөлийг, сумын удирдах зөвлөлийг аймгийн удирдах зөвлөлийн шийдвэрээр, хяналтын зөвлөлийг тухайн шатны ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулна”, 4.4.1-д “Сумын Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл нь тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулагдана”, 4.4.2-д “Удирдах зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байх ба түүний бүрэлдэхүүнд сумын Засаг дарга, ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч, эмийн сангийн эрхлэгч, иргэд болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон байна. Удирдах зөвлөлийн дарга нь сумын Засаг дарга байна” гэж заажээ.

Зүүнхангай сумын Засаг даргын захирамжаар Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийг 5 гишүүнтэйгээр байгуулсан байна. Ингэхдээ зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүнд журамд заасан иргэдийн төлөөллийг оруулсан байна.

“Сумын Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ын 4.5.1-д “Сумын хяналтын зөвлөл нь тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулагдах бөгөөд 3-аас доошгүй гишүүнтэй байна. Үүнд сумын ИТХ-ийн тэргүүлэгч, Төрийн сангийн төлөөлөгч, иргэдийн төлөөлөл болон бусад холбогдох хүмүүсийг оролцуулна” гэж заасан байна.

Зүүнхангай сумын Засаг даргын захирамжаар Эмийн эргэлтийн сангийн хяналтын зөвлөлийг 3 гишүүнтэйгээр байгуулсан байна.

#### **3.2      Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хэвийн, зарцуулалтад тавих хяналт сул байна.**

Аудитад хамрагдсан 2015, 2016 онд сумын Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, түүнд тавих хяналтын тогтолцоо байхгүй байна.

Сумын Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “Эмийн эргэлтийн сангийн хөрөнгө нь орон нутгийн өмч, гадаад байгууллагын тусламж, эмийн сангийн үйл ажиллагааны орлого болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заажээ.

Зүүнхангай сумын ЭЭСанд 2015 онд борлуулалтын орлого 24.2 сая, эмийн үнийн хөнгөлөлт 4.1 сая, хүүгийн орлого 1.4 сая, нийт 29.7 сая, 2016 онд

борлуулалтын орлого 31.2 сая, эмийн үнийн хөнгөлөлт 3.8 сая, хүүгийн орлого 1.7 сая, нийт 36.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 3.3-д “Эмийн эргэлтийн сангийн эргэлтийн хөрөнгийг аймгийн Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 7 төрлийн үйл ажиллагаанд зарцуулах”-аар заажээ.

Сумын ЭЭС-ийн удирдах зөвлөлөөс 2015, 2016 онд аймгийн Удирдах зөвлөлд хөрөнгө зарцуулах талаар хүсэлт хүргүүлээгүй байна.

ЭЭС-ийн ажиллах журмын 4.4.3-д “ЭЭС-ийн удирдах зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Тухайн жилд эмийн эргэлтийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэх асуудлуудыг үндэслэлтэй төлөвлөж аймгийн Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж төлөвлөсөн ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажлын үр дүнг аймгийн Удирдах зөвлөлд улирал бүр тайлагнах” гэж заасан байхад аудитад хамрагдсан онуудад тайлагнаагүй байна.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 3.3.2-д “Эмийн эргэлтийн сангийн хагас бүтэн жилийн цэвэр ашгийн 40 хувийг жилд 1 удаа орон нутгийн эрүүл мэндийн анхны тусламжийн чанар хүртээмжийг сайжруулахад сумын удирдах зөвлөлийн шийдвэрээр зарцуулна” гэж заасны дагуу 2015 онд сумын Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр эмийн сангийн барилгын засвар хийхээр удирдах зөвлөлийн шийдвэр гаргаж 5.8 сая төгрөг зарцуулсан байна. Ингэхдээ засварын материалыг сумын ЭЭС-ийн 1, 2 дугаар гарын үсэг зурж захиран зарцуулдаг эрх бүхий Засаг дарга, нягтлан бодогч нар бэлтгэн нийлүүлсэн байгаа нь материалын үнэ, тоо, чанарт тавих хяналт алдагдах, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй байна.

Дээрх журмын 4.4.3-д “Сумын удирдах зөвлөл нь эмийн сангийн үйл ажиллагааны зардалд улирал бүр 100.0 мянган төгрөг хүртэл зардлыг зарцуулах эрхтэй гэж заасны дагуу улирал бүр шатахууны зардалд 100.0 мянган төгрөг зарцуулсан боловч зарцуулалтын анхан шатны баримт болох жолоочийн замын хуудас хөтлөөгүй байна. Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллахыг зөвлөлөө.

### **3.3 Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт хэвийн байна.**

Сумын Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 4.3.3-д “Аймгийн Эрүүл мэндийн газар эмийн эргэлтийн сангуудаас шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн захиалгыг авч нэгтгэж нэгдсэн тендер зарлаж нийлүүлэгчийг сонгон шалгаруулж чанартай эмээр тасалдалгүй жигд хүртээмжтэй хангах ажлыг зохион байгуулна” гэж заасны дагуу аймгийн ЭМГ-аас тендер зарласан байна.

Тендерээр сумын ЭЭС нь 2015 онд 5 компаниас 13.2 сая, 2016 онд 5 компаниас 19.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ыг зөрчин тендер сонгон шалгаруулалт хийгээгүй, гэрээ байгуулахгүйгээр 2015 онд 2.3 сая, 2016 онд 8.0 сая, нийт 10.3 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Цаашид Засгийн газрын 2013 оны 68 журмаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөмж болгов.

Эмийн эргэлтийн сангийн эмийн үлдэгдэлд түүвэр тооллого хийж тулган баталгаажуулахад 2017 онд ашиглалтын хугацаа дууссан 90.0 мянган төгрөгийн

21 нэр төрлийн эм байна. Тухайн эмийг журмын дагуу актлаж устгахын аудитын явцад зөвлөлөө.

### **3.4 Эмийн эргэлтийн сангийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна.**

Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайланд 2015, 2016 онд авлага тусгаагүй байна.

Эмийн эргэлтийн сангийн хөрөнгөнд аудитын явцад хяналтын тооллого хийхэд 3956.7 мянган төгрөгийн эмийг ЭМТ-ийн эмч нарт болон иргэдэд зээлээр өгч дутагдуулжээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 4.6.4-д “аймгийн Удирдах зөвлөлөөс тогтоосон эмийн жижиглэнгийн үнийг баримтлан ажиллаж, ашиг орлогыг нэмэгдүүлж, өр авлагагүй, өмч хөрөнгийн зөрчилгүй ажиллах” гэж заасныг зөрчиж байгаа тул дутагдуулсан эмийн үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

## **Бүлэг: 4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна**

### **4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна.**

Шилэн дансны тухай хууль батлагдсанаар төсвийн болон улс, орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоо бүрдсэн.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2015 оны 2/04 тоот албан бичгээр “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлсэн байна. Увс аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн ЗДТГ-ын Дотоод хяналтын албанаас жил бүр хяналт, шалгалт хийж зөвлөмж өгч ажиллажээ.

Аудитын явцад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан мэдээллүүдээс ЗДТГ, Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг аудитын дүгнэлт, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлыг, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Shilendans.gov.mn сайтад оруулаагүй, төсөвт байгууллагууд зарим сард мэдээллийг хугацаа хоцроож байршуулдаг, төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнууд өөрчлөгдсөн боловч шилэн дансны сайтад өөрчлөлт оруулаагүй зөрчил байна. Мэдээллийг хуулийн хугацаанд оруулж холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийж байхыг зөвлөлөө.



Шилэн дансны тухай хуулийн 5.7-д "Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна" гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагууд мэдээллийн самбарт санхүүгийн мэдээ, мэдээллийг байршуулсан байна. Ингэхдээ ИТХ, Ахлах сургууль шилэн дансны мэдээллийн самбар байхгүй байгууллагын мэдээллийн самбарын санхүүгийн хэсэгт байршуулж байна. Цаашид шилэн дансны тусгай самбар гарган мэдээллийг байршуулж байхыг зөвлөлөө.

#### **4.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжилт дараах байдалтай байна.**

Зүүнхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Хөрөнгө оруулалт, ОНХС-ын хэрэгжилтийн үр дүнд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт дараах байдалтай байна.

Нийт 8 акт тогтоосноос 6 актыг бүрэн барагдуулж, 2 актын биелэлт дутуу байна. Аудитын явцад барагдаагүй актын төлбөрийн зарим хэсгийг төлүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн 6 албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумын төсөвт байгууллагуудын ажилтнуудын ээлжийн амралтын нөхөн олговрыг буруу тооцон илүү, дутуу олгосонд акт тогтоосон байна. Үүний үр дүнд 2016 оноос ээлжийн амралтын олговрыг зөв тооцож олгожээ.

Нийцлийн аудитаар нийт 16409.8 мянган төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 18000.0 мянган төгрөгийн 8 албан шаардлага, 5 зөвлөмж өглөө.

### Дүгнэлт

Энэхүү нийцлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.Үүнд:

**Зүүнхангай сумын ИТХ-ын дарга Д.Батболд, Засаг дарга Ж.Батбаяр, төсөвт байгууллагын менежерүүдэд:**

1. Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн менежерүүд улирлын урамшил авахдаа ажлаа дүгнүүлээгүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй өөрийн гаргасан тушаал дээр сумын Засаг даргаар цохолт хийлгэсэн байна.
2. Төсөвт байгууллагууд болон Эмийн эргэлтийн сангийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.
3. Байгууллагууд ойн арга хэмжээний үеэр хандиваар ирсэн 74225.7 мянган төгрөгийн 89 нэр төрлийн хөрөнгийг орлогод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.
4. Төсөвт байгууллагуудад ашиглалтын хугацаа дууссан актлах шаардлагатай хөрөнгө хадгалагдаж байна.
5. Бараа материал, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.
6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна.

### Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Зүүнхангай сумын ИТХ-ын дарга Д.Батболд, Засаг дарга Ж.Батбаяр, төсөвт байгууллагын менежерүүдэд:**

1. Улирлын урамшил олгохдоо Засгийн газрын 393 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
2. Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.
3. Ойн хандиваар ирсэн хөрөнгүүдийг орлогод авч, байгууллагын данс бүртгэлд тусгах.
4. Ашиглалтгүй болсон хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасах.
5. Бараа материал, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.


Холбогдох байгууллагын санал

  
**УВС АЙМАГ  
ЗҮҮНХАНГАЙ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА**  
213406, Зүүнхангай сум, Жаргалант.  
2017.10.10 № 79  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

┌ УВС АЙМГИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ ┐

Тус сумын төсвийн байгууллага, ЭЭС-ийн 2015, 2016 оны санхүүгийн баримтад хяналт шалгалтыг аудитор Б.Авирмэд, Т.Намжил нар 2017 оны 10 дугаар сарын 04-ээс 10 дугаар сарын 09-ны хооронд хийлээ.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, албан шаардлага хүлээн зөвшөөрч байна.

  
ЗАСАГ ДАРГА  Ж.БАТБАЯР

### **Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар**

Зүүнхангай сумын ЗДТГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 79 дугаар албан тоотоор нийцлийн аудитын тайлангийн төсөлд нэмж тусгах санал байхгүй гэсэн хариу ирүүлсэн болно.

Иймд хариу тайлбар хийгээгүй болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.АВИРМЭД

АУДИТОР

Т.НАМЖИЛ